



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД

2022.03.17 № 03/656
танай _____-ны № _____-т

Шинжээчээр хамтран ажиллах
урилга хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө, оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө” сэдэвт аудитад “Байгаль орчны нөлөөлөлд дүгнэлт гаргах шинжээч ажиллуулах” зорилгоор гэрээ байгуулан хамтран ажиллахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.

Шинжээч нь YAГ-AD/22-012 дугаартай ажлын даалгаврын дагуу тус төслийн хөрөнгө оруулагч талаас гэрээний дагуу байгаль орчны нөлөөлөл болон газрын доорх усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн нөхцөл цаашдын төлөв байдлыг шалгаж, мэргэжлийн дүгнэлт гаргах бөгөөд ажлын зорилтын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс оюу толгой ХХК, Оюу толгой ХХК, Монгол-Ус ТӨҮГ, Усны газар болон төслийн үйлдвэрлэлд ашигладаг гүний усны орд болох Галба-Өөш Долоодын сав газрыг хамруулж, гэрээт ажлыг ажлын 42 хүртэл хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Шинжээч нь ажлын даалгаварт дурдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан бичнэ.

Мэдээллээ ирүүлж буй шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, санхүүгийн дэлгэрэнгүй санал, урилгад хавсаргасан маягтаар нэмэлт мэдээллээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2019, 2020, 2021 он/;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 оны жилийн эцсийн/.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/.

Шинжээчийн ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гаргах багийн бүрэлдэхүүнд газрын доорх усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн нөхцөл цаашдын төлөв байдлыг үнэлэх

мэргэшсэн техникийн үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага, туршлагатай дүгнэлт гаргах чиглэлээр эрх бүхий зөвшөөрөлтэй иргэн, баг, хуулийн этгээд, түншлэл байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар дэмжигдсэн олон нийтийн эрх ашгийг дээдэлсэн, хууль тогтоомжид нийцсэн зарчмын шаардлагын дагуу ажил гүйцэтгэх этгээд нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байх бөгөөд Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээчид тавигдах шаардлага, хуулийн этгээдийн хувьд:

- Ижил төрлийн ажил үйлчилгээг гүйцэтгэсэн, шинжилгээ, судалгаа хийж байсан ажлын дадлага, туршлагатай байх;
- Судалгааны арга зүй ашиглаж, үнэлгээ, дүгнэлт боловсруулах, багаар ажиллах ур чадвартай байх;
- Хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй байх;
- Доор дурдсан мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх. Үүнд:

Гидрогеологич- Газрын доорх усны нөөцийн мэргэжилтэн

- Гидрогеологийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистр түүнээс дээш зэрэгтэй байх.
- 10 болон түүнээс дээш жил газрын доорх усны чиглээр судалгаа хийсэн байх.
- Газрын доорх усны хөдөлгөөн, нөөц, тоо хэмжээний чиглэлээр ажилласан туршлагатай байх.

Гидрохимич, гидрогеохимич-Усны чанар, газрын доорх усны чанарын мэргэжилтэн

- Усны хими, усны чанар, газрын доорх усны чанарын чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистраас доошгүй зэрэгтэй байх.
- 10 болон түүнээс дээш жил усны чанарын чиглэлээр судалгаа хийсэн байх.
- Усны чанарын чиглэлээр ажилласан туршлагатай байх.
- Газрын доорх усны чанарын мэдээллийн боловсруулалт, тайлалыг мэргэжлийн түвшинд боловсруулдаг чадвартай байх.

Гидротехникч-Ус ашиглалтын мэргэжилтэн

- Усны барилга байгууламжийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистраас доошгүй зэрэгтэй байх.
- 10 болон түүнээс дээш жил усны барилга байгууламжийн чиглэлээр судалгаа хийсэн байх.
- Ус ашиглалтын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн чиглэлээр ажилласан туршлагатай байх.

Экологич-Байгаль орчны мэргэжилтэн

- Байгаль орчны чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистраас доошгүй зэрэгтэй байх
- 10 болон түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй ажилласан, судалгаа шинжилгээ хийсэн байх.
- Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалал, хими болон аюултай бодис, газар, хөрс, нөхөн сэргээлт, агаар орчин болон хийн ялгаруулалтын, хог хаягдлын нөлөөллийн талаар мэргэшсэн байх.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдээллээ 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 10 минутын дотор дараах цахим хаягаар tsend-ayushn@audit.gov.mn, info@audit.gov.mn/ pdf файл хэлбэрээр ирүүлнэ үү. Хариуцсан ажилтан: Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. Гар утас: 88051068

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САРАНСҮХ



**“ОЮУТОЛГОЙ ТӨСӨЛД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН
ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ” АУДИТААР БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ БОЛОН
ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫН БАЙДАЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ
ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

2022 оны ² дугаар сарын
¹⁵ -ний өдөр

Дугаар
^{4AT-AT}
²²⁻⁰¹²

Улаанбаатар хот

Ажлын зорилт:

“Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар уг төслийн хөрөнгө оруулагч талаас гэрээний дагуу байгаль орчны нөлөөлөл болон газрын доорх усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн нөхцөл цаашдын төлөв байдлыг шалгаж, мэргэжлийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

Эхлэх хугацаа: 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дуусах хугацаа: 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр

Байршил: “Оюу толгой” төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрт

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг үндэслэн хийх “Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө” аудитын хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу мэдлэг, ур чадвар бүхий этгээдийг шинжээчээр татан оролцуулна.

ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Ажлын зорилтын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс оюу толгой ХХК, Оюу толгой ХХК, Монгол-Ус ТӨҮГ, Усны газар болон төслийн үйлдвэрлэлд ашигладаг гүний усны орд болох Галба-Өөш Долоодын сав газрыг хамруулна.

Үндэсний аудитын газрын аудитын баг төслийн төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбоотой шаардлагатай баримт материалыг дээрх байгууллагуудаас гаргуулан авна. Шинжээчийн баг бэлтгэгдсэн ажлын баримт материал, баримтат

нотлох зүйлсэд үндэслэн төслийн байршил дээр үзлэг шалгалт хийх, ажлын тоо хэмжээг тулгах, дүн шинжилгээ, тооцоолол хийнэ.

ГУРАВ.ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Усны тухай хууль, холбогдох журам, стандартуудыг баримталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа эсэх;			Усны тухай хуулийн 3.1.1."усны нөөц" гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг;
2	Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн амлалтууд усны нөөц ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох;			Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан ус ашиглах тухай заалт, Усны тухай хуулийн 3.1.2."ашиглах боломжит нөөц" гэж усны сав газрын экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр тодорхой хугацаанд ашиглаж болох усны нөөцийн хэмжээг;
3	Ус ашиглах гэрээ, түүний шаардлагуудыг хангаж ажиллаж байгаа эсэх;			Усны тухай хуулийн 29.1. Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна.
4	Уурхайн ус ашиглалтын байдал, үйлдвэрийн усны эргэлт, ус дахин ашиглалтын өнөөгийн байдлыг тодорхойлох;	Төслийн ашиглаж буй газрын доорх усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн нөхцөл цаашдын төлөв байдлыг шалгаж, мэргэжлийн дүгнэлт гаргахад	Монгол Улсын хууль тогтоомж, журам бусад хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.	3.1.27."ус ашиглагч" гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг;
5	Ус ашиглалтын барилга байгууламжууд, тоног төхөөрөмжийн нөхцөл байдал, үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх;			Усны тухай хуулийн 32.1 Усны барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих ажлыг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ. 32.4. Усны барилга байгууламж эзэмших, ашиглах эрхийг тав хүртэл жилийн хугацаагаар олгож, сунгана.

6	Усны нөөцийн нөхцөл байдал (газрын доорх усны ордын), ус ашиглалтын үйл ажиллагаанаас үзүүлэх өөрчлөлтөд дүгнэлт гаргах;	Төслийн ашиглаж буй газрын доорх усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн нөхцөл цаашдын төлөв байдлыг шалгаж, мэргэжлийн дүгнэлт гаргахад	Монгол Улсын хууль тогтоомж, журам бусад хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.	4.4. Энэ хуулийн 21.1-д заасан мэргэжлийн байгууллага нь усны нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг хайгуул, судалгаагаар тогтооно. 4.5. Усны нийт нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг усны нөөцийн зөвлөл батална.
7	Усны чанарын нөхцөл байдал, ус ашиглалтын үйл ажиллагаанаас үзүүлэх өөрчлөлтийн байдалд дүгнэлт гаргах;			Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуулийн 4.1. Ус, рашааны нөөцийг ашиглан хаягдал ус гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус бохирдуулсны төлбөр төлөгч байна.
8	Усны хяналт шинжилгээний үйл явц, үр дүнтэй байгаа эсэх;			6.2. Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээ байнгын ажиллагаатай дараах хэсгээс бүрдэнэ: 6.2.1. улсын хяналт-шинжилгээний сүлжээ; 6.2.2. сав газрын хяналт-шинжилгээний нэгж; 6.2.3. аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтын цэг.
9	Хаягдлын сангийн нөхцөл байдал, усны алдагдлын түвшинг тооцоолж баталгаажуулах;			Усны тухай хуулийн 25.1. Ус бохирдуулагч нь хаягдал усныхаа тоо хэмжээ, найрлагад хяналт тавих, хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн бохир усыг цэвэрлэж зайлуулах, ус бохирдуулсны төлбөр төлөх үүрэг хүлээнэ.
10	Хаягдал усны ашиглалтын түвшин, усны хэмжээ, чанарт дүгнэлт гаргах;			Усны тухай хуулийн 17.1.8. сав газрын хэмжээнд ус хангамжийн эх үүсвэрийн болон хаягдал ус зайлуулах цэг тогтоох; 17.1.13 хаягдал усыг зохих журмын дагуу байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах.
11	Төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдал, төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо,			Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.6. "байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж

	судалгааны үр дүнгээр хийж гүйцэтгэсэн ажлууд үр дүнтэй байгаа эсэх			болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;
12	Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх;	Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн өнөөгийн нөхцөл, цаашдын төлөв байдлыг шалгаж, мэргэжлийн дүгнэлт гаргахад	Монгол Улсын хууль тогтоомж, журам бусад хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.	8.3. Энэ хуулийн 8.2-т заасан эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгээр тайлан бэлтгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.
13	Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй бохирдлыг бууруулахад боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй техник, технологийг ашиглах зөвлөмжийг бүрэн үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх;			6.1. Төсөл хэрэгжүүлэгч нь энэ хуулийн 3.1.4-т заасан үнэлгээг хийлгэж, болзошгүй нөлөөллийг судалсан байна.
14	Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах талаар хэрэгжүүлж буй ажил үр дүнтэй байгаа эсэх;			7.1. Нөлөөллийн үнэлгээ нь дараах үнэлгээнээс бүрдэнэ: 7.1.1. байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ; 7.1.2. байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ.
15	Уул уурхайн төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг иж бүрэн тусгаж хэрэгжүүлж байгаа эсэх			9.5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. 9.6. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна.

Нэмэлт шаардлага: Тухайн гүйцэтгэх ажил, үүргийн хүрээнд нэмэлт ажил хийгдэх тохиолдолд нөхөж оруулна. Жич: Шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх, ажил үүрэг бүрд нэмэлт ажил оруулах боломжтой.

ГЭРЭЭТ АЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХЭМЖЭЭ, ФОРМАТ

Үе шатны тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 50 хуудаснаас багагүй, 250 хуудаснаас ихгүй хуудас /мөр хоорондын зай "single", үсгийн хэмжээ Arial 12/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.

- Дагалдах материал болон үнэлгээний тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.

- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль тогтоомж ном, хэвлэл, (Олон Улсын Аудитын дээд байгууллагаас гаргасан тунхаглал, Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын стандарт мэдээлэл) зэрэг эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

“Оюу толгой” төслийн хүрээнд ашиглаж буй газрын доорх усны нөөц, ус ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчны нөлөөлөл цаашдын төлөв байдлын талаар нотлох баримт, тайлан, судалгаанд үндэслэн Хөрөнгө оруулалтын гэрээ болон Монгол Улсын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхийг шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахын зэрэгцээ, дүгнэлт гаргах үйл ажиллагааны үр дүнг тусгасан тайлан бичнэ.

ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээчийн ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гаргах багийн бүрэлдэхүүнд газрын доорх усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн нөхцөл цаашдын төлөв байдлыг үнэлэх мэргэшсэн техникийн үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага, туршлагатай дүгнэлт гаргах чиглэлээр эрх бүхий зөвшөөрөлтэй иргэн, баг, хуулийн этгээд, түншлэл байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар дэмжигдсэн олон нийтийн эрх ашгийг дээдэлсэн, хууль тогтоомжид нийцсэн зарчмын шаардлагын дагуу ажил гүйцэтгэх этгээд нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээчийн ажлын хүрээнд мэргэшсэн, тухайн салбарт ажиллаж ирсэн ажлын дадлага, туршлагатай, зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, баг, хуулийн этгээд /эсвэл хуулийн этгээдийн түншлэл/-тэй хамтран ажиллана.

Хуулийн этгээдийн хувьд:

- Ижил төрлийн ажил үйлчилгээг гүйцэтгэсэн, шинжилгээ, судалгаа хийж байсан ажлын дадлага, туршлагатай байх.
- Судалгааны арга зүй ашиглаж, үнэлгээ, дүгнэлт боловсруулах, багаар ажиллах ур чадвартай байх.
- Хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй байх.
- Доор дурдсан мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх.

Гидрогеологич- Газрын доорх усны нөөцийн мэргэжилтэн

- Гидрогеологийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистр түүнээс дээш зэрэгтэй байх.
- 10 болон түүнээс дээш жил газрын доорх усны чиглээр судалгаа хийсэн байх.
- Газрын доорх усны хөдөлгөөн, нөөц, тоо хэмжээний чиглэлээр ажилласан туршлагатай байх.

Гидрохимич, гидрогеохимич-Усны чанар, газрын доорх усны чанарын мэргэжилтэн

- Усны хими, усны чанар, газрын доорх усны чанарын чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистраас доошгүй зэрэгтэй байх.

- 10 болон түүнээс дээш жил усны чанарын чиглэлээр судалгаа хийсэн байх.
- Усны чанарын чиглэлээр ажилласан туршлагатай байх.
- Газрын доорх усны чанарын мэдээллийн боловсруулалт, тайлалыг мэргэжлийн түвшинд боловсруулдаг чадвартай байх.

Гидротехникч-Ус ашиглалтын мэргэжилтэн

- Усны барилга байгууламжийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистраас доошгүй зэрэгтэй байх.
- 10 болон түүнээс дээш жил усны барилга байгууламжийн чиглэлээр судалгаа хийсэн байх.
- Ус ашиглалтын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн чиглэлээр ажилласан туршлагатай байх.

Экологич-Байгаль орчны мэргэжилтэн

- Байгаль орчны чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистраас доошгүй зэрэгтэй байх
- 10 болон түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй ажилласан, судалгаа шинжилгээ хийсэн байх.
- Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалал, хими болон аюултай бодис, газар, хөрс, нөхөн сэргээлт, агаар орчин болон хийн ялгаруулалтын, хог хаягдлын нөлөөллийн талаар мэргэшсэн байх.

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

Зөвлөх үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө” аудитын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан хуулийн этгээд, шинжээчид нь ажил эхлэхийн өмнө аудитын багтай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллана.

Шинжээчийн бүрэлдэхүүн аудитын явцад олж авсан болон мэдсэн төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийг нэгэн адил мөрдөж ажиллана.

Шинжээчийн бүрэлдэхүүн нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Аудит гүйцэтгэх үе шатны ажлын явцад үүссэн, шийдвэрлэх боломжгүй асуудал бий болсон бол тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

Бүрдүүлэх материал:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх, гэрчилгээний хуулбар;
- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар/багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);

Энэхүү ажлын даалгаврын 5-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлж, цуглуулсан бүх баримт, мэдээлэл, зөвлөмжийг хавсаргана.

ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг төгрөгөөр /Монгол/ олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г _____ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна.

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: _____

Холбоо барих утас: _____

ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1. Ерөнхий танилцуулга

.....

(Оролцогч хуулийн этгээд болон хувь хүн /баг/ нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд/баг/хувь хүн дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү.

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: _____

САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: _____

Байгууллагын нэр: _____

Мэргэжилтний нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ¹**

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.

¹ Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.